



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,

Чингис хот, Хэнтий аймаг, 23000

Утас/Факс: (976) 7056 2151

Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2023. 07. 07 № 9/1508

танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Хэнтий аймгийн 2023 оны эхний хагас жилд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн тайланг гаргаж хүргүүлэв.

Хавсралт хуудастай.



Ц.ЧОГСОМЖАВ

231050831

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
2023 оны...07... дугаар сарын...07...-ний өдрийн
9/1508... дугаар албан бичгийн хавсралт



**ХЭНТИЙ АЙМГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль", Монгол Улсын Засгийн газрын 2005 оны "Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон иргэдээс нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

2023 оны эхний хагас жилд Хэнтий аймгийн нутгийн захиргааны байгууллагад нийт 1699 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн бөгөөд үүнээс Аймгийн Засаг даргын Тамгын газарт 296 буюу 17.4 хувь, Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудад 505 буюу 29.7 хувь, Сумдын Засаг даргын Тамгын газарт 898 буюу 52.9 хувь өргөдөл ирсэн бөгөөд шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн 1647 буюу шийдвэрлэлтийн хувь 96.9 хувьтай байна. Үлдсэн 52 буюу 3.1 хувь нь шийдвэрлэлтийн хугацаа болоогүй, шинээр ирсэн өргөдөл байна.

Өргөдөл, гомдлыг ирүүлсэн байдлаар авч үзвэл нийт 1699 өргөдлийн 1123 буюу 66.1 хувь нь бичгээр, 290 буюу 17.1 хувь нь Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх "Иргэдээ сонсьё 70563111" шууд утас болон утсаар, цахим хаягаар 34 буюу 2.0 хувь, Засгийн газрын 1111 төвөөр 52 буюу 3.0 хувь, биечлэн 180 буюу 10.6%, бусад хэлбэрээр 20 буюу 1.2 хувь байна.

Өргөдөл гомдол, санал хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл нийт 1699 өргөдлийн 1674 буюу 98.5 хувийг хүсэлт, гомдол 2 буюу 0.1 хувь, талархал 7 буюу 0.4 хувь, саналын шинжтэй 16 буюу 1,0 хувийг тус тус эзэлж байна.

Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд дийлэнх нь цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, ажилласан жилийн нэмэгдэл, цалингийн шатлал ахиулах хүсэлт 344 буюу 3.7 хувь, ажил хөдөлмөр эрхлэх, ажлаас чөлөөлүүлэх, томилуулах, шилжин ажиллах хүсэлт 186 буюу 15.8 хувь, мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 147 буюу 8.7 хувь, газар эзэмших, өмчилж авах, өвөлжөө хаваржааны газрын хэмжээг өөрчлүүлэх, гэрчилгээжүүлж авах асуудлаар хүсэлт гаргасан 145 буюу 16.7 хувь, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг

цахимаар давхар төлсөн шимтгэлийн буцаалт 80 буюу 7.6 хувийг тус тус эзэлж байна.

Өргөдөл гомдлын дийлэнх хувийг хүсэлт эзэлж, өргөдөл гомдол, санал хүсэлтийг бичиг хэргийн үндсэн программд сумд, агентлагууд бүртгэн баталгаажуулан, архив албан хэрэг хөтлөлтийн үндсэн зарчимд тулгуурлан өргөдөл гомдлын тайланг ирүүлсэн. Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол бүрийг нэг бүрчлэн үзэж судлан бодитой, үнэн зөв, хуулийн хугацаанд, хугацаа хэтрүүлэхгүй шийдвэрлүүлсэн.

Аймгийн Засаг даргатай уулзах иргэдийг 70563963 дугаарын утсаар бүртгэж, АЗДТГ-ын 1-р давхарт олон нийттэй харилцах өрөөнд Засаг дарга өдөр бүр уулзалт хийж 59 иргэнтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэсэн.

Мөн Бор-Өндөр, Баянмөнх, Батноров, Баян-Овоо, Баянхутаг, Мөрөн суманд томилолтоор ажиллаж 180 гаруй иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч боломжтойг газар дээр нь шийдвэрлэж, шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдлийг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар оруулж, хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд төрийн байгууллага, албан тушаалтанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шуурхай, хугацаа хэтрүүлэхгүй шийдвэрлэх, өргөдөл гомдлын программд бүртгэж баталгаажуулалт хийгдэж байгаа, үнэн зөв бодитой шийдвэрлэгдсэн эсэхэд хяналт тавьж зөвлөмж мэдээллийг хүргүүлж ажилласан.

Аймгийн хэмжээнд өргөдөл гомдол санал хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж, Аймгийн Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудад байршуулан ажиллаж байна.

Мөн цаг үеийн шинжтэй буюу төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, үйлчилгээг өөрийн биеэр ирүүлэхгүйгээр шууд шийдвэрлэх, хурдан хугацаанд цаг алдалгүй хариу өгөх үүднээс 70563111, 98173788, 70563786, 70562027, 70562267, 77861220, 70562261, 70562868 дугаарын нээлттэй утсыг тогтмол ажиллуулж иргэдэд чирэгдэл, хүндрэл үүсгэхгүй байлгах талаас анхаарч шууд хариулт өгч ажилласан.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг шуурхай, хуулийн хугацаанд хариу өгч ажиллах тал дээр Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон ТЗУХ-ийн дарга албан байгууллагын дарга нарын шуурхай зөвлөгөөнд 7 хоног тутамд

танилцуулан, анхаарах асуудалд үүрэг чиглэл өгч, шийдвэрлэлтийн явцыг удирдлагын зүгээс хянаж ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын "Иргэдээ сонсьё -70563111" төвийн нээлттэй утас Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байрлан ажиллаж иргэдийн санал хүсэлт, Засгийн газрын 1111 төвөөр хувиарлагдан ирсэн өргөдлийг хүлээн авч Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулан харъяалан шийдвэрлэх байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж, иргэнд хариу өгч ажилласан.

Өргөдөл гомдол, санал хүсэлтийн мэдээллийг 7 хоногийн баасан гаригт АЗДТГ-ын сонсголд болон 14 хоног тутмын даваа гаригт зохион байгуулагддаг Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, khentii.mn сайтад мэдээлэн ажилласан. 2023 оны хагас жилийн тайланг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажиллалаа.

Мөн 7 хоног бүр иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж, нийтийг хамарсан асуудлаар тухайн албан тушаалтнаас хариулт авч олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ч.БАЯРЦОЛМОН

ТАЙЛАН БИЧСЭН
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЗОРИГТБАЯСГАЛАН

**Хэнтий аймгийн 2023 оны эхний хагас жилийн
нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд
гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал**

Хүснэгт -1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт / %/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэгд сэн		
1	Аймгийн ЗДТГазар	296	280			16	94.5
2	Агентлагууд	505	500			5	99.0
3	Сумд	898	867			31	96.5
Дүн		1699	1647			52	96.9

Хүснэгт-2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс					
			амаар	Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан
1	Аймгийн ЗДТГазар	296	-	112	52	6	126	-
2	Агентлагууд	505	-	475	-	16	4	4
3	Сумд	898	-	536	-	12	160	176
Нийт		1699	-	1123	52	34	290	180

Хүснэгт 3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал/ тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/	
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Нийт-296	1.Хүсэлт-291 /98.3.%/ 2. Талархал-5 /1.7%/
		1.Мөнгөн тусламж эд материалын дэмжлэг хүссэн	58 /19.6%/
		2.Газар эзэмшил, өмчлөлтэй холбогдсон	19 /6.4%/
		3.Архины эмчилгээнд хамрагдах хүсэлт	13 /4.4%/
		4.Ажил хөдөлмөр, эрхлэлттэй холбоотой асуудлаар	10 /3.4%/
		5.Байр орон сууцтай холбоотой асуудлаар	8 /2.7%/
2	Агентлагууд	Нийт-505	1.Хүсэлт- 502 /99.4%/ 2. Гомдол-1 /0.2%/ 3.Талархал-2 /0.4%/
		1.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлээ цахимаар давхарт төлсөн иргэдийн мөнгөн төлбөрийг буцаан авах хүсэлт	80 /15.8%/
		2.Ажилд орох, чөлөөлүүлэх, ажлын байрны шилжилт хөдөлгөөнтэй холбогдсон асуудлаар	75 /14.8%/
		3..Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой	32 /6.3%/
		4.Гамшгаас хамгаалах улсын байцаагчийн дүгнэлт, тодорхойлолт, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт	16 /3.2%/

		5.Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 14 /2.7%/
3	Сумд	Нийт-898 1.Хүсэлт- 882 /98.2%/ 2.Санал-16 /1.8%/ 1.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговортой хөнгөлттэй холбогдсон 312 /34.7%/ 2..Газар, эзэмшил, өмчлөлтэй холбоотой 126 /14.0%/ 3..Ажил хөдөлмөр, эрхлэлттэй холбогдсон 101 /11.2%/ 4..Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 75 /8.3%/ 5.Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд зориулсан зээлд хаирагдах хүсэлт 43 /4.7%/
4	Хэнтий	Нийт- 1699 1.Хүсэлт- 1674 /98.5%/ 2.Гомдол- 2 /0.1%/ 3.Талархал-7 /0.4%/ 4.Санал-16 /1.0%/ 1.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговортой холбоотой 344 /3.7%/ 2.Ажил хөдөлмөр, эрхлэлттэй холбогдсон 186 /15.8%/ 3.Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 147 /8.7%/ 4..Газар эзэмшил, өмчлөлтэй холбогдсон 145 /16.7%/ 5.Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлийн мөнгийг онлайнаар давхар төлсөн иргэд буцаан авах хүсэлт 80 /7.6%/ -Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлаар дийлэнх хувь нь хандсан нь ажилласан жилийн нэмэгдэл авах, тэтгэмжид хамрагдах хүсэлт, тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан ба хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэнд хариу өгсөн -Ажил хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон асуудлаар хандсан иргэдийг ажилд томилох, ажилд орох нөөцийн бүртгэлд бүртгэх, ажлаас чөлөөлөгдөх хүсэлийг хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн өөр сум болон аймаг руу шилжих хүсэлт гаргасныг хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн. Ажлын байраар хангах төсөл хөтөлбөрт 51 иргэн хамруулж, шинээр зээл олгож, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлсэн. -Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн иргэдийн хүсэлтийг судлан Аймгийн Засаг даргын нөөц сангаас мөнгөн тусламж, сумдын засаг дарга нар орон нутгийн хөгжлийн сангийн зорилтот бүлгийн хөрөнгөөс эмчилгээний зардал, буцалтгүй тэтгэмж олгосон. Сумдад хандаж ирүүлсэн эмчилгээний зээлэнд 56 иргэн хамрагдахаар судлагдан Сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэрлэж зээлийн гэрээг байгуулж мөнгөн туслаж олгосон. -2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэдэд төрөөс үнэгүй олгох газрын өргөдлийг иргэдээс хүлээн авч, өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээ олгосон. Өвөлжөө хаваржааны газраа эзэмших, өмчлөх, кадастрын зураглал хийлгэх тухай хүсэлт гаргасан иргэдийн асуудлыг Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн сумын ИТХуралд уламжилж ИТХ-ын тогтоолоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу шийдвэрлэж хариуг хүсэлт гаргасан иргэдэд хүргүүлсэн. Иргэдийн хүсэлтээр эзэмшил, өмчлөлийн газрыг хэмжилт хийж, өвөлжөө хаваржааны газрыг чөлөөлүүлэх, гэрчилгээ олгох, газрын эзэмшлийн эрх шилжүүлэх тухай хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн эзэмшлийн газраа өмчлөлийн гэрчилгээ авахаар бүрдүүлсэн

		145 иргэний материалыг хүлээн авч захирамж гаргуулан олгосон. -Эрүүл мэндийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын шимтгэлийг цахим хэлбэрээр төлсөн иргэд хариуцсан байцаагчаас мэдээлэл авахгүй өөрсдөө төлбөрийг хийснээс болж давхардал үүссэн асуудал гарч байгаа тул хүсэлтийг хүлээн авч буцаан олголтыг хийж өгөх үйлчилгээг бүрэн үзүүлсэн. - Аймгийн хэмжээнд "Иргэдээ сонсьё-70563111" утас өдөр бүр, khentii.mn сайтын цахимаар иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулан харъяалан шийдвэрлэх байгууллагад шилжүүлэн 126 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэв. Шийдвэрлэлтийн хугацаанд Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга 7 хоног тутамд хяналт тавьж ажилласан. Хяналтын явцыг албан байгууллагуудын удирдлагын түвшинд танилцууж анхаарал татахуйц, олон давтагдаж байгаа асуудлыг сайжруулах, алдаа зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох ажлыг сайжруулах чиглэл өгч, байгууллагын дүгнэх үзүүлтэд өргөдөл гомдлын шийдвэрлэлийн байдлыг дүгнэж ажилласан. • Аймгийн Засаг дарга Бор-Өндөр, Баянмөнх, Батноров, Баян-Овоо, Баянхутаг, Мөрөн суманд томилолтоор ажиллаж 180 гаруй иргэдтэй уулзаж санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжтой 9 асуудлыг шийдвэрлэсэн. • Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвөөс хувиарлагдан ирж байгаа өргөдөл бүртэй танилцан харъяалан шийдвэрлэх байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлж, шийдвэрлэлтийн бодит үр дүнг тооцон 7 хоног тутамд хяналт тавьж, анхаарах асуудлыг албан байгууллага, агентлагын дарга нарын шуурхай хуралд танилцуулан ажилласан. • Сум, агентлаг бүр 7 хоног тутамд иргэдтэй уулзах хуваарь гаргаж, иргэдийн санал бодлыг сонсож, багийн иргэдийн нийтийн хурал хийж тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж, 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдээс санал авах ажлын явцыг саналын хуудас, цахимаар хамруулж санал авсан. • Төрийн байгууллагуудад санал хүсэлтийн хайрцаг байршуулж, бүх нийтийн бэлэн байдлын үед иргэдийг заавал биеэр ирүүлэх шаардлага гаргахгүйгээр 70563111, 70562906, 98173788, 70563786, 70562027, 70562267, 77861220, 70562261, 70562868 нээлттэй утсыг тогтмол ажиллуулж, төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг шууд хүлээн авч хариулт өгч ажилласан. • Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор "Өргөдөл гомдлын цахим программ"-д бүртэлийг хөтөлж байгаа эсэх, шийдвэрлэлтийн явц, баримт бичгийг хавсаргаж байгаа эсэх, шийдвэрлэлт үр дүнтэй эсэх, байгууллагын даргын цахим бүртгэлд цохолт хийж шилжүүлж байгаа эсэхэд цахим хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажилласан. • Хэнтий аймаг Улаанбаатар хотоос Хэнтий аймгийг зорин ирэх иргэдэд боломжуудыг олгож, Нээлттэй Хэнтий аймаг цахим хуудсыг ажиллуулж, 223 иргэний асуултад хариулж мэдээллээр ханган ажилласан.
--	--	---

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН УДИРДЛАГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

№ 28

2023.07.03

Хэрлэн сум

2023 оны 07 сарын 03-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 09:00 цагт эхэлж 11:00 цагт дууссан. Ирц 100 хувьтай.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 2:

Хэнтий аймгийн 2023 оны эхний хагас жилийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан хэлэлцүүлэх

СОНССОН НЬ 2:

Тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Баярчолмон танилцуулав. Үүнд 2023 оны эхний хагас жилд Хэнтий аймгийн нутгийн захиргааны байгууллагад нийт 1699 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн бөгөөд үүнээс Аймгийн Засаг даргын Тамгын газарт 296 буюу 17.4 хувь, Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудад 505 буюу 29.7 хувь, Сумдын Засаг даргын Тамгын газарт 898 буюу 52.9 хувь өргөдөл ирсэн бөгөөд шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн 1647 буюу шийдвэрлэлтийн хувь 96.9 хувьтай байна. Үлдсэн 52 буюу 3.1 хувь нь шийдвэрлэлтийн хугацаа болоогүй, шинээр ирсэн өргөдөл байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ 2:

Хэнтий аймгийн 2023 оны эхний хагас жилийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН УДИРДЛАГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

№ 28

2023.07.03

Хэрлэн сум

2023 оны 07 сарын 03-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 09:00 цагт эхэлж 11:00 цагт дууссан. Ирц 100 хувьтай.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 2:

Хэнтий аймгийн 2023 оны эхний хагас жилийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан хэлэлцүүлэх

СОНССОН НЬ 2:

Тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Баярчолмон танилцуулав. Үүнд 2023 оны эхний хагас жилд Хэнтий аймгийн нутгийн захиргааны байгууллагад нийт 1699 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн бөгөөд үүнээс Аймгийн Засаг даргын Тамгын газарт 296 буюу 17.4 хувь, Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудад 505 буюу 29.7 хувь, Сумдын Засаг даргын Тамгын газарт 898 буюу 52.9 хувь өргөдөл ирсэн бөгөөд шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн 1647 буюу шийдвэрлэлтийн хувь 96.9 хувьтай байна. Үлдсэн 52 буюу 3.1 хувь нь шийдвэрлэлтийн хугацаа болоогүй, шинээр ирсэн өргөдөл байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ 2:

Хэнтий аймгийн 2023 оны эхний хагас жилийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

